



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 82

Өлгий сум

Аймгийн нутаг дэвсгэрээс 2022 онд ахуйн зориулалтаар
агнах, барих загасны дээд хязгаар тогтоох тухай

Монгол Улсын Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын “Ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаар батлах тухай” 2022 оны А/89 дугаартай тушаалыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Тус аймгийн нутаг дэвсгэрээс 2022 онд ахуйн зориулалтаар агнах, барих загасны дээд хязгаарыг нэгдүгээр, агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 50 хувийг хуулийн дагуу тухайн агнуурын бүс нутгийн амьтны амьдрах орчинг нөхөн сэргээх, тэтгэх, агнуурын амьтны судалгаа, мониторинг хийх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Ахуйн зориулалтаар ан амьтан агнах, барих ажлыг дээд хязгаарт багтаан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш. Марат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д. Бауыржан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.БЕЙБИТХАН


2022 оны 06 дугаар сарын 15 ний өдрийн аймгийн
иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VIII хуралдааны
22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



2022 ОНД АХУЙН ЗОРИУЛАЛТААР АГНАХ, БАРИХ ЗАГАСНЫ
ТОО ХЭМЖЭЭНИЙ ДЭЭД ХЯЗГААР

№	Сумын нэр	Загас агнах газрын нэр	Загасны хэмжээ /ширхэг/
1	Алтай	Сагсай гол	350
2	Алтанцөгц	Ховд гол	150
3	Буянт	Сагсай гол	150
4	Бугат	Ховд гол	150
5	Булган	Булган гол	0
6	Дэлүүн	Тал нуур	900
7	Улаанхус	Ховд гол	150
8	Цэнгэл	Ховд гол	150
9	Толбо	Толбо нуур	900
10	Ногооннуур	Ховд гол	150
11	Баяннуур	Ховд гол	150
12	Сагсай	Ховд гол	150
13	Өлгий	Ховд гол	150
	Дүн		3500

2022 оны 06 дугаар сарын 15 ний өдрийн аймгийн
иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VIII хуралдааны
22 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



2022 ОНД АХУЙН ЗОРИУЛАЛТААР АГНАХ, БАРИХ АМЬТНЫ ТОО
ХЭМЖЭЭНИЙ ДЭЭД ХЯЗГААР

№	Сумын нэр	Саарал чоно /ширхэг/	Шар үнэг /ширхэг/
1	Алтай	4	5
2	Алтанцөгц	4	4
3	Буянт	3	4
4	Бугат	3	4
5	Булган	3	4
6	Дэлүүн	4	4
7	Улаанхус	3	4
8	Цэнгэл	3	4
9	Толбо	3	4
10	Ногооннуур	4	4
11	Баяннуур	3	4
12	Сагсай	3	5